



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Г Шуурхай ажлын хэсгийг шинэчлэн Г
томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 10 дугаар зүйлийн 10.3.3, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.3, 44 дүгээр зүйлийн 44.1.2, 44.1.3, 44.1.4, 48 дугаар зүйлийн 48.1.1, 48.1.3, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/286 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотод гэнэтийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл ослын нөхцөл байдал үүссэн үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, удирдлага зохицуулалтаар хангах, нүүлгэн шилжүүлэлт дайчилгааг зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар, шаардагдах техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахиулан холбогдох үүрэг чиглэлээр хангаж, ажиллахыг хариуцсан дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гамшгийн шуурхай удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Мягмардорж)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Шуурхай ажлын хэсэг томилох тухай" А/03 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА,
ХУРАНДАА  ЖСЧҮЛТЭМСҮРЭН

